

“ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ – ДЭЭД БОЛОВСРОЛ”
Улсын II зөвлөлгөөний Үндэсний зөвлөлгөөний
“Дээд боловсрол - Оюутны хөгжил ” салбар хуралдаанаас
дэвшүүлж буй зөвлөмж

2018.01.27

Улаанбаатар хот

А. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Яаманд

1. “Оюутан залуусын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого” боловсруулж, хэрэгжүүлэх арга зам, санхүүжилтийг шийдвэрлэх
2. Дээд боловсролтой иргэн, мэргэжилтний эзэмшсэн байх ур чадварын жагсаалтыг гаргаж, эзэмшүүлэх аргазүйг боловсруулах, оюутны хөгжил, спортын төвийг байгуулах
3. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтанд (ЭЕШ) оруулах шалгуурыг шинэчлэн тогтоож, дээд боловсролын сургалтын байгууллагад элсэх ЭЕШ-ын босго оноог өндөрсгөх, 780-800 оноо авсан элсэгчид тэргүүлэх чиглэлээр суралцвал төлбөрийг төрөөс бүрэн даах тухай Засгийг газрын журам боловсруулж хэрэгжүүлэх, сургалтын төлбөрийн буцалтгүй тусламжид хамрагдаж байгаа суралцагчдын санхүүжилтийг сурлагын голч дүнтэй уялдуулан олгох талаар Монгол улсын Засгийн газрын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 71-р тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах
4. “Оюутны хөгжлийн зээл” нь барьцаагүй, оюутны ирээдүйн орлогод суурилж олгогдох тул суралцагчийн төгссөний дараа ажлын байраар хангаж, ажилд авсан байгууллагатай нь зээл төлөлтийн асуудлыг хамтран шийдвэрлэх, тус байгууллагыг төрийн бодлогоор дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах

Б. Дээд боловсролын сургалтын байгууллагад

1. Хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, үнэлэх чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэх, сургалтын хөтөлбөрийн болон хичээлийн үр дүнг тодорхойлох аргазүйн зөвлөмж боловсруулах, түгээн дэлгэрүүлэх
2. Оюутан залуусын зан төлөвийн түгээмэл шинжийг багш сургалтандаа тооцох тухай нарийвчилсан судалгаа хийж, дээд боловсролын байгууллагад ажиллаж буй багшийг энэ чиглэлээр мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, боловсролын үйлчилгээг ухаалаг болгох

3. Чадварлаг мэргэжилтэн, төлөвшсөн иргэн бэлтгэхийн тулд сургалтын агуулгад хувь хүний хөгжил, дадлагын цагийг нэмэгдүүлэхтэй холбоотой өөрчлөлт оруулж, ажил олгогчид, төгсөгчидтэй нягт хамтран ажиллах
4. Оюутнууд багш нарын удирдлагаар хэрэгжиж буй төсөлт ажилд оролцох болон бие даасан судалгаа хийж, судалгааны мэдээ, мэдээлэл цуглуулах, боловсруулах, үр дүнг хэлэлцүүлэх, хэвлэн нийтлэх, түгээх чиглэлээр суралцан судалгааны арга зүйг эзэмших нөхцөлийг бүрдүүлэн, судласан кредит, эзэмшсэн ур чадвар, судалгааны үр дүнгээр боловсролын зохих зэргийг (магистр) олгох
5. Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, бие бялдарын хөгжлийн сорилыг жил бүр хийж, мэдээллийн сан бүрдүүлэн, суралцагчдын эрүүл мэнд, бие бялдарын онцлогт тохирсон хөтөлбөрөөр биеийн тамир, спортын хичээлийг явуулах

В. Түнш байгууллага, ажил олгогчид, аж ахуйн нэгжүүдэд

1. Сургалтын хөтөлбөр боловсруулахаас эхлээд дадлагажих, төгсөлтийн ажил бичээд дипломаа авах хүртэл сургалтын үйл явцад дээд боловсролын байгууллагатай нягт хамтран ажиллаж, сайн мэргэжилтэн бэлтгэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх

“Дээд боловсрол - Оюутны хөгжил” салбар хуралдаанд оролцогчид